Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаат хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.5	5
Хэсгийн оноо				**4**	**3.5**	**35**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гаргасан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9.5**	**95**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:
[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”.

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн баталсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар “Сургалтын агуулга, сэдэв батлах тухай” тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

Ёс зүйн хорооны 2025 оны ... дүгээр
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нийт 132 орон тооны хязгаартай бөгөөд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.1, 2.2, 2.4 дэх заалтуудын хүрээнд нийт албан хаагчдын санал хураалтаар олонхийн дэмжлэг авсан 7 албан хаагчийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/12 тушаалаар 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ёс зүйн дэд хорооны 2 гишүүн Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу албан тушаалаас чөлөөлөгдсөн учир Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын дагуу сул орон тоог нийт албан хаагчдын санал хураалтаар нөхсөн бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/127 дугаар тушаалаар дараах нэр бүхий албан хаагчид нөхөн томилогдсон. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Ёс зүйн дэд хорооноос улиралд 2025 оны 09 дүгээр сар хүртэл 13 удаа хуралдсан. Ёс дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус арга хэмжээнүүд нь нийт албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилготой.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
1. “Ёс зүйн академи” ТББ-ын лектор, олон улсын хуульч (Ph.D) Ж.Ойнмандах багшийг урин төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг мөрдүүлэх, сурталчлан таниулах, ёс зүйн зөрлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчилд

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.
[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.
[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

хүлээлгэх хариуцлага сэдвээр 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 70 албан хаагч танхимаар, орон нутгийн байцаагч, эм шинжлэх лабораторийн 35 албан хаагчид цахимаар оролцсон.

2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт 2024-2025 онд шинээр томилогдсон 23 албан хаагчид байгууллага, төрийн албыг танилцуулах сургалт 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр танхимаар хийсэн.
3. Ёс зүйн дэд хороо болон Захиргааны удирдлагын газрын санаачилгаар 2024-2025 онд шинээр томилогдсон 31 албан хаагчдад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр АТГ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар н.Балдандорж "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр сургалт орсон.
4. Нийт албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлын хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаарх богино 3 видео бичлэг хийж байгууллагын www.mmra.gov.mn цахим хуудсанд байршуулан 30 000 хэрэглэгчдэд хүргэсэн.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

1. Ёс зүйн дэд хорооны дарга “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан.
2. Ёс зүйн дэд хороонд 2025 оны 4 дугаар улирлын байдлаар нийт Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой 3 өргөдөл 1 мэдээллийн дагуу хяналт шалгалт хийж 10 албан хаагчид ёс зүйн зөрчил гаргасанд тооцоож, дүгнэлтийг шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, хариуцлага тооцсон.
3. “Улаанбаатар марафон-2025” Олон улсын гүйлтийн тэмцээнд байгууллагаа Ёс зүйн дэд хорооны 3 гишүүн 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр оролцсон.
4. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 5 дугаар сараас эхлэн “Ёс зүйтэй төрийн албан хаагч”-ийг сар бүр 5 шалгууруар шалгаруулж нярав Захиргаа удирдлагын газрын О.Зул, Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газрын Хуурамч эм, стандартын бус эмийн тандалт, судалгааны асуудал харицсан мэргэжилтэн Д.Ганчимэг, Чанарын хяналтын газрын улсын байцаагч Д.Алимаа, Эмийн бүртгэлийн

хэлтэсийн мэргэжилтэн Т.Тунгалагтамир, Захиргаа удирдлагын газрын мэргэжилтэн Д.Даваахүү нарт батламж, гарын бэлэг гардуулсан.

5. Нийтийн мэдээллийн ил тод хангах хуулийн дагуу “Ёс зүйн хорооны мэдээллийн самбар”-ыг 03 сард хийж байгууллагын үүдний хүлээн авах хэсэгт байршуулан ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой мэдээллийг олон нийтэд болон албан хаагчдад өгч байна.
6. Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээтэй холбоотой Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын албан хаагчдын үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол, талархлыг хүлээн авахаар албан хаагч бүрийн өрөөний үүдэнд QR кодтой санал авах хуудсыг байршуулсан.
7. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 1 давхрын угтах хэсэгт албан хаагчдад зориулсан “Талархлын мод” байрлуулан, ажиллаж байна.
8. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/408 дугаар тушаалаар “Ёс зүйн зөрлийг үл тэвчих сэтгэлгээг хөгжүүлье” сэдэвт 2 сарын аяныг зарласны дагуу 2025 оны 10 дугаар сарын 27-ний өдөр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын ёс зүйн дэд хороо нь 6 үйл ажиллагаатай төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчидад зориулан гарын авлага боловсрулсан. 2. Төрийн албан хаагчийн харилцаа ханлага, ёс зүйтэй холбоотой санал, гомдол, талархал хүлээн авахаар албан хаагч бүрийн өрөөний хаалга дээр QR байрлуулсан.	1.
Санал:	

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

_____ _____ _____

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга

_____ _____ _____

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

_____ _____ _____

/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Огноо: ..... оны ..... сарын .....

БАТЛАВ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Л.БАТЗОРИГ

2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах гишүүний нэр, хамтран ажиллах байгууллага/хэлтэс
1	2	3	4	5	6
1	Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөг боловсруулан, батлуулах	Батлагдсан төлөвлөгөө	2025 оны төлөвлөгөөг газрын даргаар батлуулна.	2025 оны 01 дүгээр сар	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
2	Байгууллагад гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгааныг тодорхойлж холбогдох арга хэмжээг авах	Арга хэмжээний тоо	Газар, хэлтсийн албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулж, соён гэгээрүүлсэн байна.	8, 10 дугаар сар	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэх	Шийдвэрлэсэн гомдол мэдээллийн тоо	Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэсэн байна.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
4	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил түүнд оногдуулсан хариуцлагын бүртгэлийг цахимаар хөтлөх	Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн тоо	Мэдээллийн ил тод байдлыг хангасан байна.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

5	Шинээр томилогдсон албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн талаарх чиглүүлэх гарын авлага материалыг танилцуулсан байна.	Танилцуулсан албан хаагчийн тоо	Шинээр томилогдсон албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль холбогдох ёс зүйн хэм хэмжээнүүдийн талаар мэдээлэлтэй болсон байна.	Тухай бүр	Г.Номин Д.Номинцэцэг А.Номиндарь
6	Ёс зүйн зөрчил гаргах, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах.	Видео контентын тоо	Нийт албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг хийсэн байна.	3, 5, 10 сар	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг дарга
7	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг Газрын даргад танилцуулах	Ёс зүйн дэд хорооны тайлан	Ёс зүйн дэд хорооны тайлант хугацааны үйл ажиллагааг танилцуулсан байна.	6, 12 сар	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга
8	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагаатай холбоотой материалын бүрдлийг ханган газрын Архивын нэгжид хүлээлгэн өгөх	Хадгаламжийн нэгжийн тоо	Архивд 2025 оны хадгаламжийн нэгжийг (боть) хүлээлгэн өгсөн байна.	2026 оны 02 дугаар сар	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
9	Харилцагч аж ахуйн нэгжүүдээс албан хаагчдын төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг мөрдөж байгаа эсэх талаар сэтгэл ханамжийн судалгаа авах	Судалгааны тоо	Байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх ажлын хэсэгт судалгааны дүнг өгсөн байна.	5, 11 дүгээр сар	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
10	Ёс зүйн дэд хороо албан ёсны хэвлэмэл хуудастай болох	Хэвлэмэл хуудасны загвар	Ёс зүйн дэд хороо албан ёсны хэвлэмэл хуудастай болсон байна.	1 дүгээр сард	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг

11	Ёс зүйн дэд хороо мэдээллийн самбартай болох	Самбар	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр хүргэсэн байна.	2 дугаар сард	А.Номиндарь Б.Тэмүүлэн Д.Номинцэцэг
12	ЗГ-ын 2024 оны “Ёс зүйн хэм хэмжээг батлах тухай” 109 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-тэй уялдуулан газрын хөдөлмөрийн дотоод журамд санал өгөх ажлыг хийх	Журамд өгсөн санал	Газрын хөдөлмөрийн дотоод журамд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний зохицуулалтыг оруулсан байна.	Хагас жилд	Г.Номин Н.Гандолгор А.Номиндарь